



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/160/СТА-ТШЗ

Баянхонгор
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

1 Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Ц.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2020.01.28 № 1/20
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

E:\Users\audit_bhrj\Downloads\БНА-2020-160-СТА-ТШЗ-Гэрчилгээ.docx

2819389

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a rectangular official stamp. The stamp contains some illegible text and a central emblem. The signature is written in a cursive style.

Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Мөнхжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаарх тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 01 дүгээр сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/39 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Aculous" программ, цалингийн тооцооллыг хийхдээ "Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 28 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны нийт зардал 603,335.9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 12,066.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 28 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 26 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	6770.2	
	Дүн	1	6770.2	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал
Байхгүй

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 534776.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 534776.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь улсын төсвөөс авах 534776.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч урсгал үйл ажиллагааны зарцуулж 21.7 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Улсын бүртгэлийн төлбөртэй үйлчилгээний орлогоор 2019 онд 170000.0 мянган төгрөг төвлүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 185691.7 мянган төгрөг улсын төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөг 109.2 хувиар биелүүлсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлогоор 23395.7 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	96		
	Нийт	27	151	149		2

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлант итгэл үзүүлж аудит хийгдээгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 6770.2 мянган төгрөгийн дүн бүхий 12 гүйлгээг хоорондын тооцооны дансаар бүртгээгүй шууд зардалд хааж бичсэн.

Энэ нь "Үнэлгээ" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.10 дахь заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн дансны үлдэгдэл, гүйлгээг санхүүгийн тайлан, тодруулгад зөрүүтэй тусгагдсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,508,139.58	27,035,610.45
35	БАРАА МАТЕРИАЛ	29,508,139.58	27,035,610.45
351	Түүхий эд материал	13,689,139.58	14,007,330.45
35110	Тусгай зориулалттай материал	13,689,139.58	14,007,330.45
35300	Бэлэн бүтээгдэхүүн	275,800.00	706,980.00
354	Хангамжийн материал	15,543,200.00	12,321,300.00
35410	Бичиг хэргийн материал	142,500.00	99,300.00
35420	Аж ахуйн материал	9,051,600.00	6,687,900.00
35470	Бусад хангамжийн материал	6,349,100.00	5,534,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,003,827,086.43	958,205,558.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,003,827,086.43	958,205,558.47
392	Биет хөрөнгө	989,339,586.43	943,905,558.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	947,874,918.00	919,078,168.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,140,311.88	-15,630,086.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,000,000.00	28,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,000,000.00	-28,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	176,669,901.17	183,185,901.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-166,096,167.10	-176,687,570.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,702,800.00	79,702,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,229,447.16	-47,301,547.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,557,893.40	1,557,893.40
393	Биет бус хөрөнгө	14,487,500.00	14,300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,900,000.00	14,900,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-412,500.00	-600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,033,335,226.01	985,241,168.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,033,335,226.01	985,241,168.92
51	Засгийн газрын хувь оролцоо	1,033,335,226.01	985,241,168.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,300,000.00	14,300,000.00
51101	Өмч: - төрийн	14,300,000.00	14,300,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	728,084,860.09	679,990,803.00
51210	Өмнөх үеийн үр дүн	728,084,860.09	728,084,860.09
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-48,094,057.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	290,950,365.92	290,950,365.92
6	ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,033,335,226.01	985,241,168.92

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Огнох оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	527,569,033.00	555,241,844.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,094,833.00	14,441,944.81
120	Нийтлэг татварын бус орлого	52,094,833.00	14,441,944.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,094,833.00	14,441,944.81
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	52,094,833.00	14,441,944.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,474,200.00	540,799,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	472,474,200.00	534,776,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	472,474,200.00	534,776,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	6,023,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,023,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	514,437,708.12	583,079,418.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,437,708.12	583,079,418.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЭГ ЭЭНИЙ ЗАРДАЛ	512,335,496.12	582,017,719.68
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	361,359,557.00	409,362,726.00
210101	Үндсэн цалин	279,708,757.00	318,999,526.00
210102	Нэмэгдэл	61,420,800.00	69,243,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,325,600.00	21,120,000.00
210105	Гэрээт ажлын хөлө	8,904,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,498,943.00	50,666,028.00
210201	Тэтгэврийн даатгал	28,827,955.00	35,019,083.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,603,495.00	4,119,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,852,073.00	3,293,353.00
210204	Ажилгүйдлийн даатгал	655,947.00	748,516.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,559,473.00	7,485,184.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,969,210.00	45,794,878.00
210301	Гэрэл, цахилгаан	2,674,109.00	3,115,366.00
210302	Түлш, халаалт	42,899,085.00	40,603,150.00
210303	Цэвэр, бохир ус	2,396,016.00	2,076,362.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,301,580.00	22,344,378.00
210401	Бичиг хэрэг	7,524,805.00	8,351,429.00
210402	Тээвэр, шатахуун	1,826,700.00	2,304,335.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,893,175.00	3,906,892.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	806,900.00	3,047,522.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,434,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,701,000.00	2,732,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,040,000.00	1,080,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	400,000.00
210604	Урсгал засвар	1,661,000.00	1,252,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	3,342,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	3,342,000.00

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,645,862.40	18,730,864.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,555,850.00	6,273,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,500.00	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,600.00	148,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	5,848.00	6,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,873,064.40	11,861,864.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,859,343.72	29,044,345.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	1,000,000.00	2,234,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,859,343.72	26,809,745.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,102,212.00	1,061,699.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,040,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,040,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	102,212.00	21,699.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,212.00	21,699.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,131,324.88	-27,837,573.87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	20,256,483.22
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	20,256,483.22
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-20,256,483.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,131,324.88	-48,094,057.09

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	701,360,856.09	749,887,344.25
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,923,323.01	23,395,772.34
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,923,323.01	23,395,772.34
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	28,923,323.01	23,395,772.34
118001	Улсын тэмдэгтийн хураамж	28,923,323.01	23,395,772.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	196,963,333.08	185,691,671.91
120	Нийтлэг татварын бус орлого	196,963,333.08	185,691,671.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	196,963,333.08	185,691,671.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	196,963,333.08	185,691,671.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,474,200.00	540,799,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	472,474,200.00	534,776,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	472,474,200.00	534,776,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	6,023,000.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,023,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	701,360,856.09	749,887,344.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	701,360,856.09	749,887,344.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,371,988.00	539,738,201.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,533,400.00	405,530,654.00
210101	Үндсэн цалин	281,882,600.00	315,167,454.00
210102	Нэмэгдэл	61,420,800.00	69,243,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,325,600.00	21,120,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,904,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,325,100.00	54,498,100.00
210201	Тэтгэврийн даатгал	26,864,300.00	33,715,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,365,100.00	3,966,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,692,200.00	3,173,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	673,100.00	793,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,730,400.00	12,849,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,969,210.00	45,794,878.00
210301	Гэрэл, цахилгаан	2,674,109.00	3,115,366.00
210302	Түлш, халаалт	42,899,085.00	40,603,150.00
210303	Цэвэр, бохир ус	2,396,016.00	2,076,362.00
2104	Хянгамж, бараа материалын зардал	11,879,930.00	17,639,669.00
210401	Бичиг хэрэг	7,309,205.00	8,080,920.00
210402	Тээвэр, шатахуун	1,826,700.00	2,304,335.00
210403	Шуудан, холбоо, нигэрнэтийн төлбөр	1,893,175.00	3,906,892.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,850.00	3,047,522.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,699,900.00	3,280,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,351,900.00	1,080,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	400,000.00
210604	Урсгал засвар	1,348,000.00	1,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	3,342,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	3,342,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,964,448.00	7,418,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийцлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,747,500.00	6,823,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,500.00	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,600.00	148,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	5,848.00	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	2,234,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	2,234,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	227,988,868.09	210,149,143.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,040,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,040,000.00
2133	Улсын төсвоос олгосон санхүүжилт, шилжүүлэг	197,065,545.08	185,713,370.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,065,545.08	21,699.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		185691671.91
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох таталс, санхүүжилт	28,923,323.01	23,395,772.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,923,323.01	23,395,772.34

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	728,084,860.09	1,033,335,226.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	728,084,860.09	1,033,335,226.01
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-48,094,057.09	-48,094,057.09
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	679,990,803.00	985,241,168.92

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	472,474,200.00	472,371,988.00	534,776,900.00	534,755,201.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	472,474,200.00	472,371,988.00	534,776,900.00	534,755,201.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЭГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,474,200.00	472,371,988.00	533,736,900.00	533,715,201.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,533,400.00	363,533,400.00	405,538,700.00	405,530,654.00
210101	Үндсэн цалин	281,882,600.00	281,882,600.00	315,175,500.00	315,167,454.00
210102	Нэмэгдэл	61,420,800.00	61,420,800.00	69,243,200.00	69,243,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,325,600.00	11,325,600.00	21,120,000.00	21,120,000.00
210105	Гэрээг ажлын хөлс	8,904,400.00	8,904,400.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,325,100.00	40,325,100.00	54,498,100.00	54,498,100.00
210201	Тэтгэврийн даатгал	26,864,300.00	26,864,300.00	33,715,200.00	33,715,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,365,100.00	3,365,100.00	3,966,500.00	3,966,500.00
210203	ҮОМШО-ний даатгал	2,692,200.00	2,692,200.00	3,173,200.00	3,173,200.00
210204	Ажигүйдлийн даатгал	673,100.00	673,100.00	793,300.00	793,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,730,400.00	6,730,400.00	12,849,900.00	12,849,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,974,600.00	47,969,210.00	45,794,900.00	45,794,878.00
210301	Гэрэл, цахилгаан	4,900,000.00	2,674,109.00	3,025,200.00	3,115,366.00
210302	Түлш, халаалт	39,818,500.00	42,899,085.00	41,441,900.00	40,603,150.00
210303	Цэвэр, бохир ус	3,256,100.00	2,396,016.00	1,327,800.00	2,076,362.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,880,000.00	11,879,930.00	17,647,900.00	17,639,669.00
210401	Бичиг хэрэг	5,520,000.00	7,309,205.00	6,300,000.00	8,080,920.00
210402	Тээвэр, шатахуун	1,680,000.00	1,826,700.00	2,760,000.00	2,304,335.00
210403	Шуудан, холбоо, ингернтийн төлбөр	3,420,000.00	1,893,175.00	4,407,900.00	3,906,892.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	250,000.00	120,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	960,000.00	600,850.00	4,060,000.00	3,047,522.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,700,000.00	4,699,900.00	3,280,000.00	3,280,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	3,351,900.00	1,080,000.00	1,080,000.00
210603	Ходолмор хамгааллын хэрэглэл	00.00	00.00	400,000.00	400,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,348,000.00	1,800,000.00	1,800,000.00
2107	Томилголт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00	3,342,000.00	3,342,000.00
210702	Дотоод албан томилголт	2,000,000.00	2,000,000.00	3,342,000.00	3,342,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,061,100.00	964,448.00	1,395,300.00	1,395,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	750,000.00	747,500.00	800,000.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,500.00	69,500.00	118,800.00	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,600.00	121,600.00	148,500.00	148,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	5,848.00	6,000.00	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1000000.00	1000000.00	2240000.00	2234600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	1,000,000.00	1,000,000.00	2,240,000.00	2,234,600.00

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	1040000.00	1040000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	1,040,000.00	1,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	1,040,000.00	1,040,000.00
	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	472,474,200.00	472,371,988.00	534,776,900.00	534,776,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	472,474,200.00	472,371,988.00	534,776,900.00	534,776,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	472,474,200.00	472,371,988.00	534,776,900.00	534,776,900.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40	40	40	40
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31	31	31
620003	Үйлчлэх ажилтан	04	04	04	04
620004	Гэрээт ажилтан	04	04	04	04
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	40	40	40	40
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	32	32	32	32
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	04	04	04	04
650010	Гэрээт ажилтан	04	04	04	04

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Ж.ӨСӨХБАЯР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ *2020.01.28*

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ *2020.01.28*

